

## Судалгаанд оролцохтой холбоотой эцэг эхийн зөвшөөрөл

Хүүхдээ судалгаанд оролцуулахыг зөвшөөрөхийг танаас хүсэж байна. Таныг зөвшөөрөхөөс өмнө судалгааны хураангуй мэдээллийг танд өгөх ёстой. Та хүүхдээ судалгаанд оролцуулахыг хүсэж болох эсвэл оролцуулахыг хүсэхгүй байж болох шалтгааныг ойлгоход танд туслах чухал мэдээллийг үүнд оруулсан байх ёстой.

Та зөвшөөрөхийн өмнө судлаач танд дараах зүйлийн талаар хэлэх ёстой.

- (i) судалгааны зорилго, ажилбар, үргэлжлэх хугацаа;
- (ii) туршилтын чанартай аливаа ажилбар;
- (iii) судалгаанаас гарч болзошгүй аливаа эрсдэл, зовиур, ашиг тус;
- (iv) үр дүнтэй байж болох бусад ажилбар эсвэл эмчилгээ;
- (v) нууцыг хэрхэн хадгалах;
- (vi) асуулт, санал гомдол, гэмтэл байвал хэнтэй холбоо барих.

Шаардлагатай тохиолдолд судлаач мөн дараах зүйлийг танд хэлэх ёстой.

- (i) гэмтсэн тохиолдолд авах боломжтой нөхөн олговор эсвэл эмчилгээ;
- (ii) урьдчилан тооцоолох боломжгүй эрсдэл гарах эсэх;
- (iii) судлаач танай хүүхдийг оролцохыг зогсоож болзошгүй нөхцөл байдал;
- (iv) та эсвэл танай хүүхдээс гарах аливаа нэмэлт зардал;
- (v) та хүүхдээ оролцуулахыг зогсоохоор шийдвэл юу болох вэ;
- (vi) таны хүүхдээ оролцуулах хүсэл эрмэлзэлд нөлөөлж болзошгүй шинэ нээлтийн талаар танд хэзээ мэдэгдэх;
- (vii) судалгаанд хэчнээн хүн хамрагдах;
- (viii) судалгаанд танай хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийг ашиглахыг та хэрхэн зөвшөөрөх хэрэгтэй болох.

Танай хүүхэд энэ судалгаанд сайн дураар оролцох бөгөөд хэрэв та хүүхдээ оролцуулахаас татгалзвал эсвэл зогсоохоор шийдвэл таныг шийтгэхгүй, мөн та хөнгөлөлт тэтгэмж алдахгүй. Энэхүү баримт бичигт гарын үсэг зурна гэдэг нь судалгаа, мөн дээр дурдсан мэдээллийг танд амаар тайлбарласан бөгөөд та сайн дураараа хүүхдээ оролцуулахыг зөвшөөрч байна гэсэн үг юм. Хэрэв та хүүхдээ оролцуулахыг зөвшөөрвөл энэ баримт бичгийн гарын үсэг зурсан хуулбар, судалгааны англи хэл дээрх хураангуйг танд өгөх ёстой.

### Асуулт байна уу?

Хэрэв танд энэ судалгааны талаар асуулт, санал гомдол, бэртэл гэмтэл, санаа зовж буй зүйл байвал судалгааны хураангуй дээр бичсэн утасны дугаарыг ашиглан судлаачтай холбоо барьж болно. Хэрэв судалгааны оролцогчийн хувьд танай хүүхдийн эрхийн талаар танд асуулт байвал, эсвэл судлаачтай ярилцах боломжгүй гэж үзсэн асуулт, санал гомдол эсвэл асуудал байвал судалгааны хураангуй дээр бичсэн утасны дугаар эсвэл э-мэйл хаягаар Юта мужийн Байгууллагын хяналтын зөвлөлийн албатай холбоо барина уу.

\_\_\_\_\_  
Хүүхдийн нэр

\_\_\_\_\_  
Эцэг эх/асран хамгаалагчийн нэр

\_\_\_\_\_  
Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

\_\_\_\_\_  
Эцэг эх/асран хамгаалагч хүүхдийн хэн нь болох

Энэхүү судалгаанд оролцох зөвшөөрөл авах үед миний бие хэлмэрчээр байлцсан гэдгээ би баталж байна. Эцэг эх/асран хамгаалагчийн хэл ба англи хэлний хооронд хэлмэрчлэх зохих мэдлэг, шаардлагатай ур чадвартай гэдгээ би баталж байна. Энэ маягтад гарын үсэг зурснаараа зөвшөөрөл авч буй судлаач, эцэг эх/асран хамгаалагч хоорондоо харилцахад нь бүрэн дүүрэн хэлмэрчилсэн болохоо би баталж байна.

\_\_\_\_\_  
Хэлмэрчийн нэр

\_\_\_\_\_  
Хэлмэрчийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

**ЧУХАЛ: БХЗ хүсэлт гаргаагүй бол 2 дахь эцэг эхэд зориулсан гарын үсэг зурах талбарыг оруулах ёсгүй.**

\_\_\_\_\_  
2 дахь эцэг эх/асран хамгаалагчийн нэр

\_\_\_\_\_  
2 дахь эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

\_\_\_\_\_  
2 дахь эцэг эх/асран хамгаалагч хүүхдийн хэн нь болох

Дараах шалтгаанаар хоёр дахь эцэг эх/асран хамгаалагчаас зөвшөөрөл авах боломжгүй (тухайн нөхцөл байдалд аль нь хамааралтай болохыг чагтална уу, 45 CFR 46.408):

- Эцэг эх/асран хамгаалагч нас барсан.
- Эцэг эх/асран хамгаалагч тодорхойгүй.
- Эцэг эх/асран хамгаалагч чадамжгүй.
- Эцэг эх/асран хамгаалагч байлцах боломжгүй.
- Зөвхөн эцэг эхийн аль нэг нь хүүхдээ асран хамгаалах хууль ёсны үүрэг хүлээсэн